

Цэргийн төв эмнэлгийн Дарга-
ерөнхий эмчийн 2024 оны 07
дугаар сарын 04-ний өдрийн 432
дугаар албан бичгийн хавсралт

**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН "ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ДЭГ ЖУРАМ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ"-ИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Монгол Улсын Засгийн газрын "Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2017 оны 01 дүгээр албан даалгавар, "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын "Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай" 2017 оны А/336, 2021 оны А/83, А/71 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг боловсруулан дараах ажлуудыг эхний хагас жилийн тайлант хугацаанд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр:

1.1. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, ажиллах журам, ажил үүргийн хуваарь болон сахилга дэг журмыг чангатгаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагын зөрчлийг таслан зогсоох талаар 2024 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

1.2. Дарга-ерөнхий эмчийн тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн гишүүд эрх, үүргийнхээ дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг сар, улирал, жилээр төлөвлөн бие бүрэлдэхүүний дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэн хууль, тогтоомж, бусад эрх зүйн акт, удирдлагын баримт бичиг, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн, гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангахад чиглүүлэн ажиллахаар 2024 онд хэрэгжүүлэх ажлууддаа төлөвлөн ажиллаж байна.

1.3. Тус эмнэлгийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сахилга, дэг журам бэхжүүлэх, салбар зөвлөл"-ийн хурлаар ангийн бие бүрэлдэхүүний дунд гарч байгаа зөрчил, дутагдалд үнэлэлт, дүгнэлт хийж, ажил тасалсан болон чөлөөнөөс хоцорч ирсэн офицер, ахлагч нарт алдаа, дутагдлаа давтахгүй байх талаар үүрэг, чиглэл өгсөн. Мөн холбогдох хууль, дүрмийг судлуулах болон бие бүрэлдэхүүнд харьцааны зөрчил гаргахгүйгээр албан үүргээ гүйцэтгэх, цэргийн дүрмийг сахин биелүүлэх шаардлага тавин ажиллаж байна.

1.4. Монгол Улсын Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах өдрүүдийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явуулсан ба албан тушаалтнуудад шударга ёсыг эрхэмлэн

үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллах талаар сурталчилгаа явуулсан. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулсан ба ажиллагааны нөхцөлийг сайжруулан бие бүрэлдэхүүний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан.

1.5. Бие бүрэлдэхүүний ажлын цаг ашиглалтыг үр дүнтэй өнгөрүүлж буй байдал болон хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд нь "TIMELY" цаг бүртгэлийн программыг байгууллагадаа нэвтрүүлэн тогтмол хяналт тавин ажиллаж байна.



1.6. Эмнэлгийн камер иж бүрдэл нийлүүлэх нээлттэй тендерийг зарлаж 141 камерийг ангийн байрлалд суурилуулснаар гэмт хэрэг, осол зөрчил гарсан тохиолдлыг хянах, камераар нотлох баримтыг бүрдүүлж ажиллах нөхцөл бүрдсэн.



1.7. Аливаа гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж байлдааны туг, нууц болон дайчилгааны баримт бичгийг хамгаалах зорилгоор Поликлиникийн 5 давхарын шат болон лифтээр ордог хэсэгт чиптэй шилэн хаалга байрлуулсан бөгөөд орой 6 цагаас хойш хаалга автоматаар түгжигддэг, бие бүрэлдэхүүн нэвтрэх үнэмлэхээр нэвтрэх ангийн байрлалд ордог, гадна хүн, үйлчлүүлэгч ангийн байрлалд нэвтрэх боломжгүй болно.



Хоёр. Иргэдээс байгууллага, албан тушаалтанд ирсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн ажлын чиглэлээр:

2.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу Цэргийн төв эмнэлэгт хандан байгууллагын албан хаагчид болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, ангилан, бүртгэлд хамруулан, шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна. Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх зохион байгуулалтын хүрээнд удирдлагын цохолтын дагуу холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажилладаг болно.


2.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Төрийн бүх байгууллага өргөдөл, гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдэнэ" гэсэн заалтын хэрэгжилтийг иргэдэд хүртээмжтэй байдлаар хангаж ажиллах ажлыг зохион байгуулж өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах өрөөнд бүртгэн авдаг



2.3. Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмчийн ажиллах болон иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг нээлттэй ил тод байрлуулсан. Тус хуваарийн дагуу байгууллагын дарга-ерөнхий эмч ажлын 5 хоногт 2 удаа буюу мягмар, баасан гарагуудад ажлын өрөөндөө иргэд, үйлчлүүлэгчийг хүлээн авч уулздаг.

"Санал хүсэлтийн" хайрцагт ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 7

хоногийн 4 дэх өдөр болгон хуулийн зөвлөх, хүний нөөцийн мэргэжилтэн нар хамт шалган санал, хүсэлтийн мөрөөр гомдлыг шийдвэрлэхэд үүрэг, чиглэл өгч ажилладаг.



2.4. Тус эмнэлэгт 2024 оны II улирлын байдлаар нийт 104 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн бөгөөд уг өргөдөл, гомдлоос 96 нь хугацаандаа шийдвэрлэгдсэн. 8 өргөдлийн хугацаа сунгагдсан. Тус улиралд сайшаагдсан болон шийтгэгдсэн албан тушаалтан байхгүй болно.

Гурав. Байгууллагын ил тод мэдээллийн чиглэлээр:


3.1. Байгууллагын ажилтан алба хаагч, байгууллагаар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, хууль, тогтоомж, эрх зүйн актын талаар шинэ мэдээ, мэдээллээр хангаж ажиллаж байгаа бөгөөд дараах самбаруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгааны талаарх мэдээллийг ил тодоор байршуулан ажиллаж байна.



Зураг 1. /ЦТЭ-ийн ил тод байдал



Зураг 2. /ЦТЭ-ийн зөвлөлүүдийн үйл ажиллагаа/




3.2. Гал унтраагуурыг норм, стандартын дагуу нүдэнд харагдахуйц, авахад хялбар газарт байрлуулсан. Ангийн захирагчийн баталсан гал түймрийн аюулгүй байдлаас хамгаалах төлөвлөгөө, галын салааны томилгоо холбогдох заавар, зааварчилгаа зэргийг тасаг, нэгжүүдэд танилцуулан зааварчилгааг тухай бүр өгч ажиллаж байна. ХХАА-ны зааварчилгааг өглөө бүр ээлжийн слесарь, лифтчин, мужаан, цахилгаанчин нарт өгч, гарын үсэг зуруулан, галын эргүүлийг томилгоожуулан, ангийн жижүүрт илтгэж хэвшсэн.

3.3. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор Поликлиникийн давхар болгонд галын хорнуудыг хананд нь тогтоон, хэрэглэх заавар, зөвлөмжийг хамт байршуулсан. Мөн тасгуудын үүдэнд галын хорнуудыг хананд нь тогтоон, аюулгүйн гарцын тэмдэглэгээг зурган хэлбэрээр хананд нааж, бүдүүвч схемийг гарц бүрийн хажууд байрлуулсан.

Дөрөв. Сургалтын чиглэлээр:

4.1. Тус эмнэлгийн ХАСХОМ буюу хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад 2024 оны 01 дүгээр сард танхимаар болон цахим хаягаар мэдээлэл өгч, ХАСХОМ хэрхэн бөглөх талаар жишээ загварыг тайлбарлаж сургалт явуулсан. АТГ-аас гаргасан авлигын эсрэг видео, шторкийг цахим хаягт байршуулж, ёс зүй, сахилга баттай байх талаар мэдээлэл хүргэсэн.



4.2. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Эрүүгийн цагдаагийн албанаас “Эрүүл мэндийн салбарт санаатай, санамсаргүй үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай”, “Эмч, үйлчлүүлэгчийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр явуулсан сургалтад бие бүрэлдэхүүн идэвхитэй хамрагдсан болно.



4.3. Батлан хамгаалах яамны шинжээч, хуулийн мэргэжилтэн Л.Ганзориг “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Авлига, авлигын шалтгаан нөхцөл” сэдвээр 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтад бие бүрэлдэхүүн идэвхитэй хамрагдсан.



4.4. Тус эмнэлгийн “Ёс зүйн дэд хороо”-оос “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн харилцаа хандлага” “Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх” сэдвээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нийт бие бүрэлдэхүүнд хичээл орж тэмцээн зохион байгуулсан.



4.5. Сувилахуйн алба, Ёс зүйн дэд хороотой хамтран 2024 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд “Цэргийн төв эмнэлгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд ёс зүйн сургалт” хичээл орсон. Сувилагч, тусгай мэргэжилтэн нийт 146 ажилтан алба хаагч хамрагдсан.



4.6. Тус эмнэлэгт 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдсан “Хууль эрх зүйн өдөрлөгт” Хүний эрхийн Үндэсний комиссын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга З.Өнөржаргал “Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийг хамгаалахад хүний эрх хамгаалагчийн үүрэг”, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хуулийн зөвлөх М.Пүрэвсүрэн “Хөдөлмөрийн тухай хууль”, “Ёс зүй, харилаа хандлага” зэрэг сэдвээр сургалт явуулж ажилтан, алба хаагчдад мэдээлэл хүргэсэн.



4.7. “Олон улсын сувилагчийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Ёс зүй харилцаа хандлага”, “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаар тэмцээн зохион байгуулсан болно.



Тав. Хоногийн манаа, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар:

5.1. Цэргийн төв эмнэлгийн харуул, хоногийн манааны бүрэлдэхүүнийг дарга-ерөнхий эмчийн тушаалаар томилгоожуулж, хоногийн манааны томилгоог 15 хоногоор хийж, тухайн сарын 10, 25-ны өдрүүдэд батлуулан томилогдсон бүрэлдэхүүнээр гарын үсэг зуруулан зааварчилгаа өгч хэвшүүлж байна. Сурган зааварлах хичээлийг төлөвлөн явуулснаар томилгоот бүрэлдэхүүний дүрмийн мэдлэг, үүрэг гүйцэтгэх чадвар сайжирч, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтэд дарга-ерөнхий эмчийн баталсан хоногийн манаа шалгах хуваарийн дагуу шалган туслах ажлыг зохион байгуулж хэвшсэн ба илэрсэн, зөрчил дутагдлыг тухай бүрт нь засуулан ажилласны үр дүнд хоногийн манааны үүрэг гүйцэтгэлтэд гарсан хэрэг зөрчилгүй байна.

5.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулж ирсэн ба анхааруулах санамж, тэмдэг, тэмдэглэгээ, зурагт хуудас, галын булан, самбарын тоо ширхгийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг сайжруулан бие бүрэлдэхүүний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Зургаа. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын өмч, хөрөнгө төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулалтыг зохих хугацаанд нь тайлагнаж, төсвийн сахилга, хариуцлагыг чандлан сахиж ажиллах ажлын хүрээнд:

6.1. Санхүүгийн алба нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон Монгол Улсын "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Татварын хууль", "Нийгмийн даатгалын тухай" хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, тушаал, зааврыг удирдлага болгон санхүү бүртгэлийн ажилтанг удирдлагаар ханган, бүртгэлийн ажлыг зохион байгуулсан ба санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг нь тооцон ажиллаж байна.

6.2. Байгууллагын төсөв боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц нээлттэй, ил тод болсон байна. Shilendans.gov.mn сайтад Байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төсөл, мөн тухайн сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг ил тодоор олон нийтэд мэдээлж хэвшсэн.

Долоо. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн чиглэлээр:

7.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахын тулд улсын болон эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шилэн дансны нэгдсэн цахим хуудастай байна гэж заасны дагуу 014000500 админ хэрэглэгчийн нэрээр орж /нэвтэрч/ мэдээлэл оруулсан.

7.2. Мэдээ мэдээллийг цаг алдахгүй, үнэн, зөв, бодитой, иж бүрэн, мэргэжлийн үүднээс оруулахын тулд байгууллагын эдийн засагч, тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, нягтлан бодогч нараар шинэ хэрэглэгч үүсгэн тус тусын чиглэлийн мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж байна. Шилэн дансны тухай хуулийн 5.7, 5.8 дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын мэдээллийн самбарт цахим хуудсанд мэдээлсэн мэдээллийг сар бүр байрлуулж байна.

Найм. Биелэлт:

Цэргийн төв эмнэлгийн 2024 оны "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр баталгаажуулсан ажлууд төлөвлөгдсөн бөгөөд сар бүр тодорхой ажлуудыг шат дараалалтай тасралтгүй явуулах ажлын хүрээнд эхний хагас жилийн

байдлаар дээрх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөний дагуу тодорхой чиглэл хариуцсан ажилтан алба хаагчид төлөвлөсөн ажлуудаа амжилттай хийж гүйцэтгэсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 96%-тай байна. Цэргийн төв эмнэлгийн хэмжээнд сахилга, хариуцлага, дэг журам сайжирч байгаа болно.

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ